

С.НАДМИД



Тоодой Цоохондой хоёр

С.НАДМИД



Тоодой Цоохондой хоёр

Улаанбаатар хот
2007 он

**С.Надмид
Тоодой, Цоохондой хоёр**

Хайрт ээж Насангийн Даариймаагийн
бага насны амьдралаас сэдэвлэв.

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураач С.Мэнхтогтох
Хянан тохиолдуулагч О.Мэнхтуяа
Дизайнер Т.Дэлгэрмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



Энэ хот айлынхан Тоодой Цоохондой хоёрыг ав адилхан хайлрадаг байлаа. Нэг нь тохойн чинээ биетэй тоодойсон бор охин, негеэ нь няvtalхan¹ үстэй нялх цоохор ишиг. Хоёулаа өнчин, хоёулаа балчир амьтад.

Тоодойг төрүүлэхээс болж хеөрхий ээж нь өөд болжээ. Ямар хэцүү байсныг хеөрхий охин яахин мэдэх билээ. Ядахдаа аав нь байхгүй. Эх орны алс зүүн хязгаарт, одоо сураг чимээгүй. Гамшигт дайн эхлээгүй бол эх эндэж, элэг эмтэлсэн ийм явдал тохиолдохгүй байсан ч байж мэднэ.

Тэр хавар муухай их хавсрата салхи тавьжээ. Хоёр хөгшин гэрээ хэр чадлаар дулаалж гайгүй сайн тэнчээлж² бэхэлсэн авч бүрээс туургыг нь гэнэт дайрсан хуй салхин хуулан авч хаясан юм гэдэг. Ийм л нэгэн золгүй явдал тэднийхийг нөмөрч, тун саяхан нярайлаад

¹ няvtalхan - нимгэн, тачир

² тэнчээлж - сэтгэл зовних

байсан залуу эхийн хөлстэй биенүүг түмэн зүү шиг хүйтэн салхи шивчихсэн хэрэг.

Хүүхдэд эхгүй болохоос илүү зовлон байхгүй. Чингээд охин өвөө, эмээ хоёртойгоо үлдэв. Сүрхий чанга дутай хөржүү амьттан байлаа. Тэр, дуу таслахгүй чарлаж, хоол нэхсээр байжээ. Өвөө нь сандарч чингэлэг авдраа онгичин өвөл төхөөрөн гүнжны эвэр олж, тулмайг³ нь мулт цохиод, шаз халуун усаар угаав.

Энэ сацуу үүцнээс үлдсэн өвчүүний хормойноос хөхийг нь салган өвчиж, хөхөлж бэлтгэжээ. Ашгүй сайхнаас сайхан том хөхтэй дэлэн байсан гэдэг. Эмээ ч мэгдэн сандарч арга тасрахдаа сая саасан үнээний сүүг хөвөнд шингээн, охины аманд дусаасанд, тэрбээр гэнэт чимээгүй болж, хариугүй улаан хэлээ булталзуулан тамшаалсан нь үнэнхүү өрөвдөм байв.

Охинд Дарь гэсэн нэр өгчээ. Энэ нэрийг түүний чихэнд шивнэсэн хүн бол Насан өвөө юм. Үхсэнээс үлдсэн амьтныг хүн болгох гэж хечнээн зовсныг хэрхэн тоочиж барах билээ. Түүнд ганцхан хар хайнагийн сүү өгнө. Анх энэ үнээний сүүгээр амлуулсан болоод ч тэр үү, өөр малын сүү өгөхгүй гэж эмээ өвөө хоёр ярьж тохирсон байжээ.

Дарь нэг амиар илүү ч үгүй, дутуу ч үгүй нэг л эвэр сүү хөхдөг, өчүүхэн дундуур болохыг ер анддаггүй, нэхэж чарлан заавал нэмүүлж санаа амардаг байв. Охинд өвчин тусаж сандаргах нь гайгүй. Гэлээ ч юмыг яаж мэдэх вэ гэж болгоомжлон Насан өвөө муу тэргэн дээрээ байнгын чингэлэг өөжин засаж, эсгийгээр дулаалав. Хэрэг болуужин гэж тэрэгнийхээ том гуныг өдөржин уяж сойно. Охиных эмч үрүү яаралтай авч явах болж гэм бэлэн байх гэж тэр.

Дарь сар өдер өнгөрөх тусам хөржиж, хеерхнэес хеерхэн божийсон бор жаал болж байлаа. Эхийгээ дуурайсан гэж жигтэйхэн. Эх шигээ хачин урт, өтгөн сормуустай, давхраатай том алаг нүдтэй. Эвэр дүүрэн сүүгээ хөхөж цадаад нөгөө сайхан алаг нүдээрээ мэлтийтэл инээвхийлэн эрхэлж, тарваадах нь хоёр хөгшний эзлэг зүрхийг хайлгах ид шид болно.

³ тулмай

-Эвий минь, хөөрхий минь! Чамайгаа бид яаж ийгээд хүн болгохсон доо!

-Тоодойсон жаахан үр минь эрүүл энх байгаасай билээ дээ.

Хоёр хөгшин охиноо нэрээр нь дууддаггүй байлаа. Зүгээр л Тоодой гэж өхөөрднене.

Охин хөлд орж, тэнтэр тунтар гишгэх болсон цагаасаа тийнхүү Тоодой хэмээн нэрлүүлэх болжээ. Хүүхэд хөлд орно гэдэг уртэй хүний нэг баяр байдаг. Тоодой гэнэт нэг өдөр эвэр мөмөн тэвэрчихсэн тулганыхаа захад зогсож байлаа. Эхлээд өвөөгөө, дараа нь эмзэгээ харж хөлд орсноо мэдгэгжээ. Түүнийг анх хөлд орсон тухай хожим хойно болтол ярьж хөхрөлдөгсөн. Айлынхаа хоёр нүд нь таг сохор өвөөг гэрт тэмтэчсээр орж ирэх тоолонд охин босож зогсон, хөлд орсноо бас л харуулах гэж өвдөөс нь том том хардаг байсан гэдэг.

Тоодойн өсөх бүр энэ айлд баяр баясгалан нэмэгдэж байлаа. Харин чин үнэнийг хэлэхэд өөрт нь огт өөр байдал эхлэв. Хот айлд тоглох хүүхэд байсангүй. Хурга ишигтэй л хөөцөлднө. Гэлээ ч хурга ишиг гэдэг хүүхэд биш шүү дээ. Тэдний хойноос Тоодой л гүйхээс биш тэд охин руу гүйж ирэх нь угүй. Үргэнэ, айна. Хамгийн гол нь бух хурга ишиг ээжтэй учир цем эхээ бараадах дуртай.

Чингэтэл Тоодой салж хагацахгүй сайн найзтай боллоо. Энэ нь Цоохондой ишигхэн юм. Адилхан хувь заяа тэднийг ийнхүү ижилсүүлэн дасгажээ.

Охиниг зургаан настай байхад Цоохондой тэрсэн юм. Харамсалтай нь түүнийг гаргахаас болж эх нь нүд аньж билээ. Энэ айлд бас л нэг үй гашуу боллоо. Монгол хүн ийм тохиолдолд адилхан үй гашуу болдог юм. Ишигний эх хэдэн жил сувайрсны эцэст ганцхан удаа ишиг гаргасан нь тэр. Өөр шигээ нуруун дээрээ хүрэн толбонуудтай цэнхэр ишиг гаргаад хөөрхий нүд аньжээ. Эх үрийн хагацах мөчид охин яг дэргэд нь байв. Хэдий жаахан балчир ч муу юм болж буйг тэр сайн ухаарч байлаа. Хөөрхий ямааг ухрийн ширэн дээр тавьж, барааны цаагуур чирч явахад Тоодой нялх ишигтэй үлдсэн юм. Эх ямаа ишгээ нэг ч удаа долоож үнэрлэж чадсангүй, сэрийсэн дэлэнгээ ч хөхүүлж чадсангүй билээ. Тийн бяцхан цоохор



ишиг анх удаа өөрийгөө өхөөрдөн суугаа охины эрхий хурууг хоол эрэн үмхсэн гэдэг. Энэ сацуу Тоодой гэр үрүүгээ гүйн орж, өөрийн эвэр мээмийг эрж олоод тоготой сүүнээсээ хийж, ишигний аманд барьсанд модгор сүүлээ хөдөлгөн сүүг учиргүй ховдоглон хөхжээ.

Ингэж охин ишиг хоёр дундаа нэг эвэр мөэмтэй болов. Хоёулаа мөнөөхөн хар хайнагийн сүүг хөхнө. Тоодой бол эвэр мөэмнөөсөө гаралгүй удсан хүүхэд. Бүр сургуульд орох дэхсен үедээ ч сүү, цай хийж хөхдөг байсан юм.

Охин ишиг хоёр хаана л бол хамт явна. Цоохондой эхгүй болохоор хүнийг л дагадаг байлаа. Тоодой ч хайртай гэж аргагүй. Сүүнд ётон дурж өөрөө шимээд, сайхан амттай болохоор нь Цоохондойдоо хөхүүлнэ. Ингэсээр ишигхэн хүний иддэгээс хүртдэг, иддэг болов. Ётонд бүр ч их дуртай болжээ. Охин хайртай ишгээ цатгах аргыг мэддэг байв. Өвертөө юм уу, хормой дороо нууж, сүүтэй ямаан

дор тавьж гувшуулна. Цоохондойг мөргөх гэдэг, түүнээс дэлэнгээ харамладаг ямаанд охин үнэн голоос дургүй.

Тоодойг байгаагүй бол Цоохондой хэцүүхэн л байх байсан. Тэр өнчин ишиг боловч гялталзсан ёстай, цовоо хеөрхөн яваа нь чухамдаа Тоодойн ач. Тун хеөрхөн ишиг. Цэхэр хүрээтэй, тод шаргал нүдтэй. Засчихсан юм шиг бийрэн сахалтай. Өндөр бараа, хадан дээр гарч өрөөсөн хөлөө өргөөд тургих их дуртай. Бараанаас үсэрч буугаад огцом хэд дэвхэрна. Одоо Цоохондой өнчин гэхээргүй ийм л хеөрхөн амьтан болжээ. Энэчлэн охин бас өнчин боловч айлын эрх хүүхэд болоод байв. Гэлээ ч томчуулын нүдээр хараход энэ хоёрын адил төстэй амьдрал цаанаа хеөрхийлэлтэй санагдана. Хоёулхнаа хотын захад эрхэлж явааг нь харсан хүмүүс эрхгүй шүүрс алддаг билээ.

Насан өвөө элгээ эмтлэн, нулимын унагадаг удаа ч буй. Зуны нэг бүгчим халуун өдөр гэрийн хаяа шуулттай байлаа. Охин гэрт, ишиг гадаа гэрийн сүүдэрт уяатай, хоёулаа аванай л эрхэлж байв. Нэг харсан чинь охин ишиг хоёр ханын нүдээр хошуугаа нийлүүлээд унтчихсан байжээ. Өвөөгийн өр зүрх шимширч, уйлсан учир нь тэр. Энэ өдрөөс хойш Насан өвөө ишгийг гэрийн гадаа уяхыг болжээ.

Ингэж Цоохондой ишиг бүрэн эрх эдэлж үд дундын шатаам халуун нарнаар гэрт байж, тэгэхдээ бур Тоодойн орон дээр хэвтэж байдаг болчухай. Сэруун орохоор Тоодойтой хамт гадагш гарна. Гэм нь хонь хургатай хамт идээшлэх дургүй. Тоодойг хурганд явсан үед л дуртайяа хамт явах бөгөөд хэчинээн шилбүүрдэвч, охин уруу эргэж майлаад байна. Энэ ч бас аргагүй байжээ. Юу гэвэл түүнийг нэг широн эвэртэй ухна ишиг мөргөх гэж үргэлж хөнөө. Нэг удаа нимгэн цавиар нь эврээрээ олих сандаргахад Тоодой аварч хамгаалсан билээ. Ингэхдээ бас ишиг ч охиныг аврах удаа олон. Үүнийг гагцхүү Тоодой л мэддэг байж болзошгүй. Тэр ямаан хорхойноос үхтлээ айдаг болой.

Тоодой Цоохондой хоёр хээр явж байжээ. Охин хел жийн хэвтэж, ишиг хажууд нь байлаа. Үзэхүл Тоодойн бяцхан бугуйн дээр дэргэр урт эвэртэй ямаан хорхой явж байв. Охин сүнсээ зайлтал айж, үсрэн босвол Цоохондой мөнөөхөн муу хорхойг тэр даруй зууж, хэмх хазжээ. Түүнээс хойш Тоодой широн эвэрт ухна ишигт өшөөтэй шиг Цоохондой ямаан хорхойд өштэй болсон юм. Хаана үзэгдсэн газраа

хорхойг хазаж, дэвсэлж хаядаг байлаа. Ер ямаанаас гармааргүй хачин "ухаан" Цоохондойд байжээ.

Нэг удаа охин хонь хариулж яваад эрээн даавуун алчуураа хөдөө гээснийг Цоохондой ишигхэн зуугаад ирсэн юм. Ингэж бяцхан цоохор ишиг бусад ямаанаас этгээд өөр гэгдэх болов. Өсөж томрох тусам тэр "ухаан" нь охинд төдийгүй, хот айлынханд мэдэгдэж эхэлжээ.


Одоо урьдыг бодвол Цоохондой сүрэгтэй хамт бэлчээрлэнз. Тийн бэлчээрлэж явахад нь хонинд чоно орсон бөгөөд үргэж цочсон сүрэг хотондоо давхиж ирэхэд нэг төлөгний хамт Цоохондой алга байлаа. Насан өвөө тэднийг эрэхээр явав. Төлгийг хойд гуунд боохой зоогложээ. Цоохондой алга. Тэгсэн чинь Цоохондой хээр тавьсан тракторын доор хэвтэж байлаа. Хөнгөн шархаджээ. Хүмүүс их гайхсан юм.

-Цоохондойгоос өөр ямаа байсан бол хэзээний бариулчихсан. Амь зулбаж тракторын доор орсон байна. Мен ч ухаантай амьтан юмаа гэж Насан өвөө ярьсаар иржээ.

Тэр явдлаас хойш Цоохондой дахиад сүрэгтэй хамт бэлчээрлэхээ бараг больсон бөгөөд Тоодой ч түүнийг явуулахдаа дургүй болсон хэрэг.

Бас нэг ийм явдал болов. Охин хонь хариулж яваад хээрээс нэг муу өттэй хурга олж ирэв. Тоодой хеерхий хургыг их өрөвджээ. Түүнийг авчраад өвөө, эмээ хоёртойгоо хамжин өтчилж, хамууны тоосоор угааж цэвэрлэлээ.

Энэ явдал Цоохондойд таалагдсангүй. Охиныг хурга уруу очиход дагаж гүйнэ. Өөрийг нь харамлаж буйг Тоодой мэдэж байв. Сүүлдээ хургыг мөргедег болжээ. Цоохондойн эвэр жаахан боловч урагшаа матигар, үзүүр нь сүрхий хурц билээ. Тоодой ишигнийхээ эврийг хараад "Нөгөө муу дээрэлхүү ухнатай мөргөлдөх гэж л ийм хурц эвэртэй болж байгаа юм даа" хэмээн боддог байв. Тэгээд "Цоохондой чи бушуухан том сайхан ямаа болооч. Муухай муу чононоос хариугаа аваач" гэж түүнд хэлдэг байлаа. Ишиг хариуд нь "Чи биттий сургуульд яваарай. Чамайг явчихвал чоно намайг идчихнэ дээ" гэж хэлдэг байв. Жаахан хендийрсэн даруй барааны газраас харчхаад майлж ирэхэд нь охин ингэж хэлж байна хэмээн итгэдэг байжээ.



Тоодойг нэг удаа эмээтэйгээ хамт ойролцоо аж ахуйн төв ороод ирэхэд Цоохондой тун ч хэцүү байсан. Тэр Тоодойд дэндүү их дасчээ. Ижил сүргээ тоono гэж үгүй. Хэрэв зээ охиныг нээрээ сургуульд орох болж гэмээнэ Цоохондой хэрхэхсэн билээ! Тоодойн хувьд ч түүнийг орхиод нэгтээ одно гэдэг санаанд багтамгүй. Цоохондойн цангинан майлах, тургиж дэгдэх дандаа сонсогдоор, харагдсаар байх болно доо. Хүн мал хоёр ингэлтлээ ижил дасал болно гэдэг ховорхон ч байж мэднэ.

Санаснаар хоёрөнчин, тийм чудаан хамт байсан гүй. Нэглмэдэхэд Тоодой найман нас хүрчээ. Түүнийг холын замд мордуулахаар өвөө эмээ хоёр нь бэлтгэсээр байлаа. Улаан торгоор дээл хийж өгөв. Талийгаач эхийн нь алтан зэмгийг авдарнаас гаргалаа. Охины чихийг

эрт цоолж, цайны шилбэ хийхээр хэдэнтээ зовоосны учир тэр ажээ. Бас ногоон даалимбаар номын сав оёж, дээлнээс үлдсэн улаан торгоор таван хошуу эсгэн, хатуу цааснаа жонхуудан наагаад дээр нь өнгийн утсаар даруулжээ. Тоодой сургуульд оруулах гэж ийнхүү хөл болж буйг сайн мэдэж байлаа.

Чингээд нэг өдөр охин аян замд мордох болов. Бүр нялхаас нь гэрийн гадаа зэхээстэй байдаг байсан мөнөөхөн чингэлэгт тэргээ хеллөөд өвөөгийнхөө хамт аж ахуйн төв орохоор хеделчухай. Охиныг айл саахалтынхан цем гаргаж өгөв. Цоохондой хойноос нь харж, уйтгартайя хоцорлоо. Охин эргэн эргэн харж “Чи одоо том ямаа болжээ. Чамайг хэн ч айлгахгүй. Муу чоно ч дийлэхгүй. Би одоо сургач боллоо” хэмээн ярьж явлаа.

Охиныг аж ахуйн төв дээр танил айлд түр суулгасан бөгөөд намар оройхон өвөө эмзэх хоёр нь малаа айлд тавиад нүүж иржээ. Тэд охиноо санаад хөдөө байж тэссэнгүй. Охин ч хэрхэн чадах билээ.

Тэр өвөл зудархуу, хавар нь бас хатуухан болсон юм. Охин Цоохондойдоо сэтгэл их зовж байлаа. “Яаж даарч байгаа бол” гэж бодно. “Эвэр нь хэр зэрэг том болсон бол” гэж бодно. “Арсад гуай түүнийг суран хуйваараа шавхуурдаж байгаа болов уу” гэж бодно. Арсад гэгч тэдний айлын хүн. Цоохондойг хэтэрхий эрх гэж түүнд дургүй билээ. Нэг удаа Цоохондой Арсадын гэрт орж, тогоотой сүүнээс нь ууж, суран хуйваар шавхуурдуулсан юм байжээ.

Цоохондойн нүд зеөлөн дулаан хамар дандаа харагдаж, хөлөө өргөн тургих дуу нь үргэлж сонсогддог байлаа. “Хавар түргэн болоосой. Цоохондой ишиглэх байх. Өөртэй нь адилхан цовоо цоохор ишиг гарна даа” гэж охин тэсгэлгүй хүсэн мөрөөднө. Эмзэ өвөө хоёр нь:

-Цоохондой чинь ноднин сувайрсан. Энэ жил ишиглэх байх гэж ярьдаг байжээ. Охин яагаад ч юм бэ, Цоохондойг ишиглээсэй билээ гэж бодно. Ишигтэй болчихвол түүнд ямар ч уйтгартай, үргэлж түүнтэйгээ тоглож, өөрийг нь ч үгүйлэхгүй болох юм шиг санагддаг байв.

Сургууль тарлаа. Насан өвөө гэрээ ачаалж хөдөө тийшээ хеделлэө. Одоо удахгүй охин Цоохондойтойгоо уулзана. Цоохондой

охины барааг харуут жаахан ишгээ дагуулан майлсаар хурч ирнэ. Тэгээд тэргэн дээр нь (ер том ямаа болсон гэхгүй) үсрэн гарч, бас тэрэгнээс хайран бууж, зээр шиг хөнгөхнеөр хэд хэд дэгдэн, охины ирсэнд баярласнаа илэрхийлэн хөгжилтэй цовоо тургилна.

Тэднийх нутагтаа ирж буулаа. Охин бөөн баяр хөөр. Тэр юун түрүүнд хоттой хонь руугаа Цоохондойгоо хүлээн ширтсээр.

-Цоохондой хаана байна? Яагаад гүйж ирэхгүй байна? Ишгээ хөхүүлээд завгүй байгаа юм болов уу? Ишгэндээ тэр маань миний найз ирнэ хэлзэе болов уу?

Охин тэссэнгүй хоттой хонь тийш гүйлээ. Дундуур нь явлаа. Цоохондой байх янзгүй. Тэр тэссэнгүй “миа-миа” гэж дуудлаа. Тоодой түүнийг дандаа ингэж дууддаг байсан юм.

Үзтэл Тоодой Цоохондой хоёр дахиад уулзахаасаа нэгэнт өнгөрчээ. Үүнийг охин тунчиг удалгүй мэдсэн билээ. Юу гэвэл айлынх нь эзэгтэй охиныг сургуулиасаа ирлээ гэсэн ч юм уу, аягаар дүүрэн бууз хийж өгсөн бөгөөд Арсад нэг л юм хэлэх гээд байснаа охины толгойг илж:

-Чиний негее Цоохондой чинь бууз болчихсон шүү дээ гэжээ.

Охин тэр даруй учрыг мэдээд буузнаас ганц ч хазалгүй гүйжээ. Маргааш нь тэр Цоохондойнхоо цоохор арьсыг олж үзсэн болой.

Тийнхүү Тоодойг хоттой хонь үргэтэл сандран гүйсээр гэртээ орж ирсэнд өвөө нь тас хар царайтай юм сууж байлаа. Охин орон дээр түрүүлгээ харж унажээ. Насан өвөө тэсэж чадсангүй гарч айлдаа орлоо.

-Арсад муу чоно чи яж байгаа чинь энэ вэ? Охины маань хайртай ямааг... Чи энэ хоёрыг ямар амьтад гэж мэднэ шүү дээ. Өөр гудрах юм олдсонгүй юу? Ээ чааваас, ингэж сүйд хийх гэж дээ хэмээн үглэнэ. Арсад гэгч олигор хех хүн ер тоосон шинжгүй:

-Дандаа гэрт байх гээд хэцүү мал. Би чинь ямаа байтугай хүүхэд ч эрхлүүлж үзээгүй хүн. Тэгээд ч чи дуртайгаа идшинд хэрэглээрэй гээ биз дээ? Одоо яая гэхэв, охинд чинь нэг хеерхэн ишиг зааж өгемэз гэжээ.

-Хэрэггүй зээ хө. Ямар ч ишиг охинд минь хэрэггүй. Охиныг минь ингэж харлуулчих гэж. Хүний үнэргүй үхээр! гэж хэлээд Насан өвөө Арсадын үүдийг хаян гарч одлоо.

Чингээд тэр даруй малаа ялган, гэрээ ачаалж тэднийхээс салж нүүсэн гэдэг билээ.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.